

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ /ХХААГ/

2020.05.29

Заалтын дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын дугаар	Хариуцах байгууллага	Хэрэгжилт бичих чиглэл	Үнэлгээ
ЗГ-ын тогтоол					
19	Жагсаалт батлах тухай 2019-05-12 Дугаар 2019_190	3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг баримтлан хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХХААГ	2019 онд уг салбарыг төсөл сонгон шалгаруулахдаа нэг шалгуур үзүүлэлт болгон хэрэгжүүлэн ажилласан. ЖДҮХСангаас нийт 9 төсөлд олгосноос уг жагсаалтын дагуу 7 төсөлд 495,0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлийг олгосон байна. Энэ онд ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 4 сарын 17-ны өдрийн А-131 тоот тушаалаар ЖДҮХСангаас хөнгөлөлттэй зээл олгох, салбар чиглэлийг баталсан. Уг чиглэлийн дагуу 4 сарын 20-ны өдрөөс 5 сарын 19-ны өдөр хүлээн авсан. Манай аймагт 30 аж ахуйн нэгжийн 2,7 тэрбум төгрөгний хүсэлт бүхий төсөл ирээд байна. Иж бүрдэл шалгах шат хүлээгдэж байна.	70
34	Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-01-15 Зг тогтоол-18	2. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, үндэсний боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эд, бүтээгдэхүүнээр бүрэн хангаж, хүчин чадлаас давсан нөөцийг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжих, түүхий эдийг үнэгүйдэхээс хамгаалах бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХОХБТХ ХХААГ	Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолын дагуу үндэсний боловсруулах үйлдвэрт хонь, тэмээний ноос бэлтгэж тушаасан малчин, мал бүхий 1811 иргэнд 700289 кг ноосонд 1,018,491,200.00 ₮-ийн мөнгөн урамшуулал, мөн Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий 1999 иргэнд хонь 133826 ш, ямаа 133295ш, үхэр 1780ш, адуу 284ш, нийт 269185ш арьс ширэнд 776,034,000.0 төгрөгний мөнгөн урамшуулал олгогдоод байна.	100
35		4. Сумдад малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, хүлээн авах, стандартын дагуу ангилан ялгалт болон чанарын хамгаалалт хийж, зориулалтын дагуу хадгалах, тээвэрлэх, борлуулах сүлжээг хоршоодод тулгуурлан бий болгох талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	ХХААГ, МЭГ	2020 оны ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээлд арьс шир, түүхий эд боловсруулах, анхан шатны тордолт хийж стандартын дагуу бэлтгэх чиглэлээр 6 аж ахуйн нэгжийн 570,0 сая төгрөгний төслийн хүсэлт ирээд байна. Хугацаа болоогүй.	40
ЗГ-ын албан даалгавар					
50	Төрийн үйлчилгээнд цахим	1.3. Цахим гарын үсгийн хуулийн	ТЗУХ	Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого	100

	төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03	хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх.	/тоон гарын үсэг олгож байгаа бүх газар агентлагууд хэрэгжилт гаргах/	болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайланг цахим татварын системийг ашиглан улирал бүр тоон гарын үсгээр баталгаажуулан илгээж байна.	
56	Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, отор, нүүдлийн зорилготой мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай 2020-02-10 Ерөнхий сайдын албан даалгавар-01	1.3, 1.4, 1.5. 1.3 Харьяалах нутаг дэвсгэрт отор нүүдэл хийх, дамжин өнгөрөх чиглэл, хугацааг тогтоож, хяналт тавих; 1.4 Отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хэсгийг томилж, үүрэгжүүлэх; 1.5 Отор нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийх явцад болон зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг, зэмийг цуглуулах, устгах, халдваргүйтгэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	ХОХБТХ, ХХААГ, МЭГ	Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч гадны 11 аймгийн 54 суманд 648 өрх 539498 толгой мал отроор өвөлжиж, хаваржиж байна. Отор нүүдлээр яваа малчдыг аймаг, орон нутгаас 1-2 удаа газар дээр нь очиж нөхцөл байдал, оторлолтой нь танилцсан. Мөн оторлолтоор яваа малчдад 01/74, 01/81 дугаар албан тоотуудаар арга зүйн зөвлөмж хүргүүлэн ажилласан	100
58		1.7. Хүндэрч болзошгүй сумдад өвс тэжээлийн нөөцийг цаг алдалгүй хүргүүлэх; 1.8 Хаагдаж болохуйц зам даваанд тогтмол пост гарган хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах;	ХОХБТХ, ХХААГ	Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан Засгийн Газрын 2019 оны 419 дугаар тогтоолоор тус аймгийн улсын нөөцөд байсан 159,750,000 төгрөгний үнэ бүхий 410 тн өвсийг үнэгүй, 82,700,000 төгрөгний үнэ бүхий 350 тн тэжээлийг 50 хувь хямдруулан сумдад хуваарилан малчдад тараан олгосон. Аймгийн ХХААГ, Онцгой байдлын газарт тус бүр 1 УАЗ-22069 маркийн фургон автомашин хуваарилан албан хэрэгцээнд ашиглаж байна. Отор нүүдэл зохион байгуулах, штаб гаргах, малчдад төрийн үйлчилгээг хүргэх зорилгоор аймгийн ЗДТГ-т 50,000,000 төгрөгийн хуваарилан олгосон.	100
Дундаж: 100-4, 70-1 , Хугацаа болоогүй-1					94